



УЛСЫН ХОЁРДУГААР ТӨВ  
ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН  
ТУШААЛ

2020 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А/ЗВ


Улаанбаатар хот

**"Эрүүл мэндийн ажилтны ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлэх журам"**  
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт, 395 дугаар тогтоол болон эмнэлгийн Удирдлагын зөвлөлийн 2020 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэл болгон ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн ажилтны ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлэхэд нэгдсэн аргачлалаар хангах зорилгоор "Эрүүл мэндийн ажилтны ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлэх журам"-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Шинэчлэн батлагдсан журмыг ажил хариуцсан дэд захирал, хэсэг, тасгийн эрхлэгч, албадын дарга нарт танилцуулахыг Эрсдэл, дотоод аудит, чанарын албаны дарга (З.Аръяасүрэн)-д үүрэг болгосугай.
3. Хэсэг, тасаг, албадын Хамт олны хурлаас гаргасан эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны ажлын үнэлгээ, дүгнэлтийг улирал бүр Удирдлагын зөвлөлд танилцуулан, хэлэлцүүлж байхыг Хүний нөөцийн хөгжлийн албаны дарга (Н.Баярмаа), Эдийн засаг, төлөвлөлтийн алба (Б.Ариунболд) нарт даалгасугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал (Ц.Ганзориг), Бодлого төлөвлөлт, хөгжлийн асуудал эрхэлсэн дэд захирал (Ц.Билэгтсайхан), Эрсдэл, дотоод аудит, чанарын албаны дарга (З.Аръяасүрэн) нарт үүрэг болгосугай.
5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан эмнэлгийн захирлын 2019 оны А/42 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



С.ЭНХБОЛД

13220038

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн  
ерөнхий захирлын 2020 оны 04  
дугаар сарын 10 -ны өдрийн  
А/ЗБ дугаар тушаалын хавсралт

**УЛСЫН ХОЁРДУГААР ТӨВ ЭМНЭЛЭГ  
ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТНЫ АЖЛЫН ҮР ДҮН, ГҮЙЦЭТГЭЛИЙГ  
ҮНЭЛЖ, УРАМШУУЛАЛ ОЛГОХ ТУХАЙ  
УХТЭ-БМ-03 ТҮЖ 1:2020-5**

Улсын Хоёрдугаар Төв Эмнэлэг	Баримтжуулсан мэдээллийн төрөл: ТҮЖ	Нийт хуудас: 10
	Гарчиг: Эрүүл мэндийн ажилтны ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлж, урамшуулал олгох тухай	
Анх боловсруулсан: Н.Баярмаа, Л.Хандсүрэн, Б.Ариунболд	Анх боловсруулсан огноо: 2014.05.05	
Баталсан: С.Энхболд	Өөрчилсөн огноо: 2020.04.10	
Хэвлэл: 5-р хэвлэл	Шалгаж шинэчлэх огноо: 2023.04.10	

Улаанбаатар хот  
2020 он

**ЭХ ХУВЬ**

Улсын Хоёрдугаар Төв Эмнэлэг	Баримтжуулсан мэдээллийн төрөл: ТҮЖ	Нийт хуудас: 10
	Гарчиг: Эрүүл мэндийн ажилтны ажлын үр дүн гүйцэтгэлийг үнэлж, урамшуулал олгох тухай	
Боловсруулсан: Н.Баярмаа, Б.Ариунболд	Анх боловсруулсан огноо: 2014.05.05	
Баталсан: С.Энхболд	Өөрчилсөн огноо: 2020.04.10	
Хэвлэл: 5-р хэвлэл	Шалгаж шинэчлэх огноо: 2023.04.10	

## БАРИМТЖУУЛСАН МЭДЭЭЛЭЛ

Баримтжуулсан мэдээлэлд өөрчлөлт оруулсан бүртгэл		
Өөрчлөлт оруулсан огноо	Өөрчлөлт хийсэн хүн	Гарын үсэг
2014-11-01	Н.Баярмаа	
2017-05-19	Н.Баярмаа	
2019-06-01	Н.Баярмаа	
2020-04-10	Н.Баярмаа	

### Журамд оруулсан өөрчлөлт

- Гурав дахь хэвлэлд 20% -аас дээш өөрчлөлт орсон тул бүртгэлд оруулаагүй болно.

ЭХ ХУВИЙ

Улсын Хоёрдугаар Төв Эмнэлэг	Баримтжуулсан мэдээллийн төрөл: ТҮЖ	Нийт хуудас 10
	Гарчиг: Эрүүл мэндийн ажилтны ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлж, урамшуулал олгох тухай	
Боловсруулсан: Н.Баярмаа, Б.Ариунболд	Анх боловсруулсан огноо: 2014.05.05	
Баталсан: С.Энхболд	Өөрчилсөн огноо: 2020.04.10	
Хэвлэл: 5-р хэвлэл	Шалгаж шинэчлэх огноо: 2023.04.10	

## БАРИМТЖУУЛСАН МЭДЭЭЛЭЛ

### АГУУЛГА

	Хуудас
1. Зорилго	4
2. Тараах жагсаалт	4
3. Норматив иш таталт	4
4. Нэр томъёо, тодорхойлолт	4
5. Хамрах хүрээ	4
6. Үүрэг хариуцлага	5
7. Үйл ажиллагаа	5-7
8. Хяналт	7
9. Хавсралтууд:	
Хавсралт 1 "Эмнэлгийн мэргэжилтэнг ажлын гүйцэтгэлээр үнэлэх шалгуур үзүүлэлт"	8
Хавсралт 2 "Эмнэлгийн бусад ажилтанг ажлын гүйцэтгэлээр үнэлэх шалгуур үзүүлэлт"	9
Хавсралт 3 "АНХААРУУЛАХ ХУУДАС"-ны маягт	10

ЭХ ХУВЬ

Улсын Хоёрдугаар Төв Эмнэлэг	Баримтжуулсан мэдээллийн төрөл: ТҮЖ	Нийт хуудас: 10
	Гарчиг: Эрүүл мэндийн ажилтны ажлын үр дүн гүйцэтгэлийг үнэлж, урамшуулал олгох тухай	
Боловсруулсан: Н.Баярмаа, Б.Ариунболд	Анх боловсруулсан огноо: 2014.05.05	
Баталсан: С.Энхболд	Өөрчилсөн огноо: 2020.04.10	
Хэвлэл: 5-р хэвлэл	Шалгаж шинэчлэх огноо: 2023.04.10	

## БАРИМТЖУУЛСАН МЭДЭЭЛЭЛ

### 1.0 ЗОРИЛГО

Энэ журмын зорилго нь Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт, 395 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын дагуу Улсын хоёрдугаар төв эмнэлгийн ажилтны ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлэх нэгдсэн аргачлалаар хангахад оршино.

### 2.0 ТАРААХ ЖАГСААЛТ

01, 02, 03, 07, 08, 11, 12, 13, 14, 15, 16, 18, 19, 20, 21, 22, 23, 24, 25, 29

### 3.0 НОРМАТИВ ИШ ТАТАЛТ

Энэхүү баримт бичиг нь дараахь баримт бичгийн сүүлчийн хэвлэлийг үндэслэл болгон тусгаж, иш татан хэрэглэнэ. Үүнд:

1. Монгол Улсын "Хөдөлмөрийн тухай хууль" 1999 он
2. Монгол Улсын "Эрүүл мэндийн тухай хууль" 2011 он
3. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"
4. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 395 дугаар тогтоол "Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай"
5. Эрүүл мэндийн сайдын 2019 оны 406 дугаар тушаал "Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм"-г шинэчлэн батлах тухай
6. Эмнэлгийн даргын 2016 оны 03 дугаар тушаал "Улсын хоёрдугаар төв эмнэлгийн хөдөлмөрийн дотоод журам"

### 4.0 НЭР ТОМЬЁО, ТОДОРХОЙЛОЛТ

**Эмнэлгийн мэргэжилтэн:** Хүний, их бага эмч, нүүр амны их эмч, сувилагч, эм зүйч, эх баригч, эм найруулагч, нийгмийн эрүүл мэндийн болон анагаах ухааны боловсрол олгох их дээд сургууль, коллеж төгссөн эмнэлгийн бусад ажилтнууд

**Эрүүл мэндийн ажилтан:** Эмнэлгийн мэргэжилтэн болон эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаа бусад ажилтнууд

### 5.0 ХАМРАХ ХҮРЭЭ

Энэ баримтжуулсан мэдээлэл нь Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт, 395 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын дагуу Улсын

Улсын Хоёрдугаар Төв Эмнэлэг	Баримтжуулсан мэдээллийн төрөл ТҮЖ	Нийт хуудас 10
	Гарчиг: Эрүүл мэндийн ажилтны ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлж, урамшуулал олгох тухай	
Боловсруулсан: Н.Баярмаа, Б.Ариунболд	Анх боловсруулсан огноо: 2014.05.05	
Баталсан: С.Энхболд	Өөрчилсөн огноо: 2020.04.10	
Хэвлэл: 5-р хэвлэл	Шалгаж шинэчлэх огноо: 2023.04.10	

## БАРИМТЖУУЛСАН МЭДЭЭЛЭЛ

хоёрдугаар төв эмнэлгийн эрүүл мэндийн ажилтны ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлж, мөнгөн урамшуулал олгох үйл ажиллагаанд хамаарна


### 6.0 ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

- 6.1 Эмнэлгийн захиргаа нь эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны мөнгөн урамшууллыг тогтоосон хугацаанд олгох үүрэг хүлээнэ.
- 6.2 Сар бүрийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээгээр хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр уг журмын шалгуур үзүүлэлтийг зөрчиж, урамшуулал дүгнэгдээгүй эмнэлгийн мэргэжилтэн, ажилтанд "АНХААРУУЛАХ ХУУДАС" өгнө (Хавсралт 3).
- 6.3 Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр дараалан 4 удаа, жилдээ нийт 6 удаа "АНХААРУУЛАХ ХУУДАС" авсан тохиолдолд Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлд заасны дагуу Эмнэлгийн даргын тушаалаар сахилгын шийтгэл ногдуулна.

### 7.0 ҮЙЛ АЖИЛЛАГАА

#### 7.1 Урамшуулал олгоход баримтлах үзүүлэлт


- 7.1.1 Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан нь ажил олгогчтой хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байгаа байгууллагын үндсэн ажилтан байна.
- 7.1.2 Ажлын үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн биелэлт 71-ээс дээш хувьтай байна.
- 7.1.3 Өвчтэй, чөлөөтэй байсан ажилтанд урамшууллыг ажилласан хоногт хамаарах хувиар тооцож олгоно
- 7.1.4 Туршилтын хугацаа болон дагалдан ажиллуулах хугацаанд ажиллаж байгаа эмнэлгийн ажилтанд урамшуулал олгохгүй.
- 7.2 Доорхи шалгуур үзүүлэлтийн аль нэг заалтыг хангаагүй эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны сарын ажлын гүйцэтгэлийн үнэлгээг харгалзахгүйгээр урамшуулал олгохгүй.
- 7.2.1 Мэргэшил эзэмших болон мэргэжил дээшлүүлэх гадаад, дотоодын сургалтанд хамрагдсан хугацаанд.
- 7.2.2 Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан ээлжийн амралт эдлэх хугацаанд нь олгохгүй.
- 7.2.3 Эмнэлгийн даргын тушаалаар сахилгын шийтгэл бүхий ажилтан Сахилгын шийтгэл эхэлсэн сараас нь эхлэн сахилгын шийтгэлийг дуусах хүртэлх хугацаанд ноогдох урамшууллыг олгохгүй. Сахилгын шийтгэл ногдуулсан ажилтан нь байгууллагын дотоод журмын дагуу эмнэлгийн даргын тушаалаар хугацаанаас нь өмнө сахилгын шийтгэлийг хүчингүйд тооцсон тохиолдолд урамшууллыг тушаал гаргасан өдрөөс эхлэн олгоно.
- 7.2.4 Тайлант сард эмнэлгийн тусламж, үйлчилгээний зөрчил гаргасан



Улсын Хоёрдугаар Төв Эмнэлэг	Баримтжуулсан мэдээллийн төрөл: ТҮЖ	Нийт хуудас: 10
	Гарчиг: Эрүүл мэндийн ажилтны ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлж, урамшуулал олгох тухай	
Боловсруулсан: Н.Баярмаа, Б.Ариунболд	Анх боловсруулсан огноо: 2014.05.05	
Баталсан: С.Энхболд	Өөрчилсөн огноо: 2020.04.10	
Хэвлэл: 5-р хэвлэл	Шалгаж шинэчлэх огноо: 2023.04.10	

## БАРИМТЖУУЛСАН МЭДЭЭЛЭЛ

- 7.2.5 Тайлант сард ажилтантай холбоотой ёс зүйн хэм хэмжээний зөрчил, гомдол гаргасан. Үйлчлүүлэгч болон ажилтнаас гаргасан гомдол, өргөдлийг үндэслэнэ.
- 7.2.6 Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан нь эмнэлгийн нөхцөлд зохистой хувцаслах дүрмийг мөрдөөгүй.
- 7.2.7 Тухайн сард эмнэлгийн ажилтан нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажлын цагийн хоцрогдолтой.
- 7.2.8 Тухайн сард эмнэлгийн ажилтан нь эмнэлгийн захиргаанд урьдчилан мэдэгдэлгүйгээр ажил тасалсан.
- 7.2.9 Гадаад болон дотоод аудитын шалгалтаар зөрчил гаргасан.
- 7.2.10 Эмнэлгийн захиргаа, алба, тасгийн эрхлэгчээс тухайн сард төлөвлөгдсөн болон ажлын шаардлагаар яаралтай өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлээгүй
- 7.3 Гүйцэтгэлийг үнэлэх:**
- 7.3.1 Эмнэлгийн дэд захирал, алба, хэсэг, тасгийн эрхлэгч нар хариуцан ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтэн, ажилтанг сар бүр батлагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэнэ (хавсралт 1, 2).
- 7.3.2 Эрүүл мэндийн ажилтны ажлын үр дүн, гүйцэтгэлийг дүгнэсэн үнэлгээг алба, хэсэг, тасгийн эрхлэгч хамт олны хурлаар хэлэлцүүлэн дүгнэлт гаргана.
- 7.3.3 Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны сарын ажлын үнэлгээг алба, хэсэг, тасгийн хамт олны хурлаас гаргасан дүгнэлтийг үндэслэн эмнэлгийн Удирдлагын зөвлөлөөр хэлэлцэн, эрүүл мэндийн ажилтанд мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг улирал бүр Эмнэлгийн ерөнхий захирал гаргана.
- 7.3.4 Албаны дарга, хэсэг, тасгийн эрхлэгчийн сарын ажлын үнэлгээг ажил хариуцсан дэд захирал нар үнэлнэ.
- 7.3.5 Ажил хариуцсан дэд захирал, Хүний нөөцийн хөгжлийн албаны дарга, Санхүү бүртгэлийн албаны дарга, Эрсдэл, дотоод аудит, чанарын албаны даргын ажлын үр дүн, гүйцэтгэлийг Эмнэлгийн ерөнхий захирал үнэлнэ
- 7.3.6 Эмнэлгийн ажил хариуцсан дэд захирал, алба, тасгийн эрхлэгч нар хариуцсан алба, тасгийн эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны үр дүнгийн гүйцэтгэлийн үнэлгээг хамт олны хурлаар хэлэлцүүлсэн дүгнэлтийн хамт сар, улирал бүрийн 6-ны дотор Хүний нөөцийн хөгжлийн албанд өгнө.
- 7.3.7 Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны сарын ажлын үнэлгээ, алба, тасгийн хамт олны хурлаас гаргасан дүгнэлтийг Хүний нөөцийн хөгжлийн алба, Эдийн засаг, төлөвлөлтийн албанаас эмнэлгийн Удирдлагын зөвлөлд улирал бүр танилцуулж, эрүүл мэндийн ажилтанд мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг Эмнэлгийн ерөнхий захирал гаргана
- 7.4 Сар бүрийн урамшуулал дүгнэх аргачлал:**
- 7.4.1 Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны ажлын үр дүн, гүйцэтгэлийн мөнгөн урамшууллыг батлагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, шаардлага



Улсын Хоёрдугаар Төв Эмнэлэг	Баримтжуулсан мэдээллийн төрөл: ТҮЖ	Нийт хуудас 10
	Гарчиг: Эрүүл мэндийн ажилтны ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлж, урамшуулал олгох тухай	
	Боловсруулсан: Н.Баярмаа, Б.Ариунболд	
	Анх боловсруулсан огноо: 2014.05.05	
Баталсан: С.Энхболд	Өөрчилсөн огноо: 2020.04.10	
Хэвлэл: 5-р хэвлэл	Шалгаж шинэчлэх огноо: 2023.04.10	

## БАРИМТЖУУЛСАН МЭДЭЭЛЭЛ

хангасан тохиолдолд улирал тутам батлагдсан төсөвт багтаан зохих суутгалуудыг суутгаж тооцож олгоно.

- 7.4.2 Эрүүл мэндийн ажилтны ажлын үр дүн, гүйцэтгэлийг "Бүрэн хангалттай", "Хангалттай", "Хангалтгүй" гэсэн үнэлгээгээр, сар бүр дүгнэнэ.
- 7.4.3 Ажлын үр дүнгийн үнэлгээнээс хамааран урамшууллын хувь хэмжээг дараахь байдлаар олгоно:

Бүх шалгуурын биелэлтийн хувь	Ажлын үр дүнгийн үнэлгээ	Албан тушаалын үндсэн цалингаас урамшуулал тооцох хувь (сард)
90-100	Бүрэн хангалттай	11-20 хувь
71-89	Хангалттай	10 хувь хүртэл
70 ба доош	Хангалтгүй	Урамшуулал олгохгүй

## 8.0 ХЯНАЛТ

- 8.1 Эрүүл мэндийн ажилтны ажлын үр дүн, гүйцэтгэлд алба, тасаг, хэсгийн эрхлэгч, ахлах сувилагч хяналт тавина.
- 8.2 Тасгийн эрхлэгч, албаны даргын ажлын үр дүн, гүйцэтгэлд ажил хариуцсан дэд захирал хяналт тавина.

ЭХ ХУВЬ



Улсын Хоёрдугаар Төв Эмнэлэг	Баримтжуулсан мэдээллийн төрөл: ТҮЖ	Нийт хуудас 10
	Гарчиг: Эрүүл мэндийн ажлтын ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлж, урамшуулал олгох тухай	
Боловсруулсан: Н Баярмаа, Б Ариунболд	Анх боловсруулсан огноо: 2014.05.05	
Баталсан: С Энхболд	Өөрчилсөн огноо: 2020.04.10	
Хэвлэл: 5-р хэвлэл	Шалгаж шинэчлэх огноо: 2023.04.10	

## БАРИМТЖУУЛСАН МЭДЭЭЛЭЛ

Хавсралт 1

### ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТЭНГ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛЭЭР ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

№	Шалгуур үзүүлэлт	Шалгуур оноо	Авах оноо	Шалгуур бүрээр авсан оноо	Авсан оноо
1	Эмчилгээ, үйлчилгээний стандартыг мөрдөж байгаа байдал	10	40		
	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, халдвар хамгааллын дэглэмийг мөрдөж байгаа байдал	10			
	Эмчилгээ, үйлчилгээний талаар гаргасан гомдол	5			
	Үйлчлүүлэгчид зөвлөгөө өгсөн байдал	5			
	Үр дүнгийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтод заасан ажлын гүйцэтгэл, чанар	10			
2	Үйлчилгээний чанар	Хүлээлгэж чирэгдүүлэлгүй үйлчилгээ үзүүлсэн байдал	5	15	
		Ес зүй хэм хэмжээний зөрчил, харьцаа, хандлагын гомдол	5		
		Үйлчлүүлэгч, хамт олны сэтгэл ханамжийн байдал	5		
3	Ажлын ачаалал, хариуцлага	Ажлын цаг ашиглалт	10	30	
		Ажлын ачаалал, удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврын биелэлт	10		
		Хариуцсан өмч хөрөнгийн ашиглалт	5		
		Албан хэргийн бүртгэл, хөтлөлт, тайланг хугацаанд нь гаргасан байдал	5		
4	Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд оруулсан хувь нэмэр	Эмчилгээ үйлчилгээнд шинэ бүтээл, оновчтой санааг нэвтрүүлэн, эдийн засгийн үр өгөөжийг тооцсон байдал	5	15	
		Үргүй зардлыг багасгах талаар тодорхой санал санаачилга гарган ажилласан байдал	5		
		Ажлын идэвх, олон нийтийн арга хэмжээнд оролцсон байдал	5		
Нийт дүн			100%		
Бүрэн хангалттай 90-100%					
71-89% - Хангалттай					
70 ба доош - Хангалтгүй					

ЭХ ХУВЬ

Улсын Хоёрдугаар Төв Эмнэлэг	Баримтжуулсан мэдээллийн төрөл: ТҮЖ	Нийт хуудас 10
	Гарчиг: Эрүүл мэндийн ажилтны ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлж, урамшуулал олгох тухай	
Боловсруулсан: Н.Баярмаа, Б.Ариунболд	Анх боловсруулсан огноо: 2014.05.05	
Баталсан: С.Энхболд	Өвөрчилсөн огноо: 2020.04.10	
Хэвлэл: 5-р хэвлэл	Шалгаж шинэчлэх огноо: 2023.04.10	

## БАРИМТЖУУЛСАН МЭДЭЭЛЭЛ

Хавсралт 2

### ЭМНЭЛГИЙН БУСАД АЖИЛТАНГ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛЭЭР ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

№	Шалгуур үзүүлэлт		Шалгуур оноо	Авах оноо	Шалгуур бүрээр авсан оноо	Авсан оноо
1	Хариуцсан ажлын чанар	Стандарт мөрдөж байгаа байдал	10	40		
		Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, халдвар хамгааллын дэглэмийг мөрдөж байгаа байдал	10			
		Ажлын байрны тодорхойлолтод заасан ажлын гүйцэтгэл, чанар, гомдол гаргасан эсэх	10			
		Удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврын биелэлт	10			
2	Үйлчилгээний чанар	Хүлээлгэж чирэгдүүлэлгүй үйлчилгээ үзүүлсэн байдал	5	15		
		Ёс зүй хэм хэмжээ, харьцаа, хандлагын гомдол гаргасан эсэх	5			
		Үйлчлүүлэгч, хамт олны сэтгэл ханамжийн байдал	5			
3	Ажлын ачаалал, хариуцлага	Ажлын цаг ашиглалт	10	30		
		Ажлын ачаалал	10			
		Хариуцсан өмч хөрөнгийн ашиглалт	5			
		Албан хэргийн бүртгэл, хөтлөлт, тайланг хугацаанд нь гаргасан байдал	5			
4	Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд оруулсан хувь нэмэр	Эмчилгээ үйлчилгээнд шинэ бүтээл, оновчтой санааг нэвтрүүлэн, эдийн засгийн үр өгөөжийг тооцсон байдал	5	15		
		Үргүй зардлыг багасгах талаар тодорхой санал санаачилга гарган ажилласан байдал	5			
		Ажлын идэвх, олон нийтийн арга хэмжээнд оролцсон байдал	5			
Нийт дүн				100%		
Бүрэн хангалттай 90-100%						
Хангалттай 71-89%						
70 ба доош - Хангалтгүй						

ЭХ ХУВЬ

Улсын Хоёрдугаар Төв Эмнэлэг	Баримтжуулсан мэдээллийн төрөл: ТҮЖ	Нийт хуудас 10
	Гарчиг: Эрүүл мэндийн ажилтны ажлын үр дүн гүйцэтгэлийг үнэлж, урамшуулал олгох тухай	
Боловсруулсан: Н.Баярмаа, Б.Ариунболд	Анх боловсруулсан огноо: 2014.05.05	
Баталсан: С.Энхболд	Өөрчилсөн огноо: 2020.04.10	
Хэвлэл: 5-р хэвлэл	Шалгаж шинэчлэх огноо: 2023.04.10	

## БАРИМТЖУУЛСАН МЭДЭЭЛЭЛ

Хавсралт 3

### АНХААРУУЛАХ ХУУДАС

20... оны ... дугаар сарын ... -ний өдөр

№ ...

\_\_\_\_\_ тасаг, хэсэг, албанд \_\_\_\_\_ ажилтай

\_\_\_\_\_ овогтой \_\_\_\_\_ нь

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн Ерөнхий захирлын баталсан "ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТНЫ АЖЛЫН ҮР ДҮН, ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЭХ ЖУРАМ"-ын

5.2.4, 5.2.5, 5.2.6, 5.2.7, 5.2.8, 5.2.9, 5.2.10 -р заалтыг зөрчсөн тул

анхааруулж байна.

Санамж: цаашид хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр дараалан 4 удаа, жилдээ 6 удаа уг "АНХААРУУЛАХ ХУУДАС"-ыг авсан тохиолдолд Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлд заасны дагуу эмнэлгийн даргын тушаалаар сахилгын шийтгэл ногдуулах болно.

Хуудас олгосон:

Эмнэлгийн ерөнхий захирал \_\_\_\_\_ ( \_\_\_\_\_ )  
( Гарын үсэг )

Хуудсыг бүртгэсэн:

Хүний \_\_\_\_\_ нөөцийн \_\_\_\_\_ хөгжлийн \_\_\_\_\_ албаны дарга \_\_\_\_\_  
( \_\_\_\_\_ ) ( Гарын үсэг )

